

ТӨСӨЛ

ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, НЭГДСЭН БОДЛОГО

Нэг. Нийтлэг зүйл.

Зорилт: Гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийн судалгаанд суурилсан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх дунд, болон богино хугацааны бодлого тодорхойлж, гэмт хэрэг, зөрчлийн тухай мэдээллийг судалсны үндсэн дээр гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэхэд нөлөөлж байгаа шалтгаан, нөхцөл, хүчин зүйлийг тогтоож, түүнийг арилгахад чиглэсэн эдийн засаг, нийгэм, эрх зүйн болон сургалт, гэмт хэрэг гарч байгаа шалтгаан, нөхцөлийг арилгах, бууруулах ажлыг зохион байгуулж, гэмт хэрэг, зөрчил гарах эрсдлийг бууруулж, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, хүн хүч, техник хэрэгсэл, хөрөнгийн бааз суурийг бэхжүүлж, чадавхижуулж, байгууллага хоорондын хамтын ажиллагааг сайжруулан, иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх ажлыг тасралтгүй, хүртээмжтэй явуулж бодит үр дүнд хүргэнэ.

Зорилт-1 Жил бүр гэмт хэрэг, зөрчил гарах шалтгаан нөхцөлийг тодорхойлох /ерөнхий, тодорхой төрлийн гэмт хэргийн/, гэмт хэрэг, зөрчлийн хэрэг гарч байгаа шалтгаан, нөхцөлд дүн шинжилгээ хийж, шалтгаан нөхцөлийг арилгах нийгэм, эдийн засгийн асуудлыг төлөвлөн хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах,

Зорилт-2 Гэмт хэрэг, зөрчил гарах эрсдлийг бууруулах,

Зорилт-3 Гэмт хэрэг, зөрчлийн хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх тогтолцоог бүрдүүлэх, бааз суурийг бэхжүүлэх,

Зорилт-4 Гэмт хэрэг, зөрчлийн хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэхэд бүх нийтийн хамтын ажиллагааг өргөжүүлэх,

Зорилт -5 Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх,

1 дүгээр зорилтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ:

1.1. Аймаг, сум, баг, байгууллага, аж ахуйн нэгж бүр орон нутаг, нутаг дэвсгэр, орчиндоо гарсан гэмт хэрэг зөрчлийн хэргийн шалтгаан, нөхцөлийг судалж, тогтооно.

1.2. Гэмт хэргийн шалтгаан, нөхцөлд дүн шинжилгээ хийж, холбогдох байгууллагуудаас өгч байгаа зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах, шалтгаан нөхцөлийг арилгана.

1.3. Гэмт хэрэг, зөрчлийн хэргийн шалтгаан нөхцөлийг судлах, тодорхойлох баг, ажлын хэсгийг ажиллуулна.

1.4. Гэмт хэрэг, зөрчлийн хэргийн шалтгаан нөхцөлийг арилгах төлөвлөлт хийж, гүйцэтгэлийг хангана.

1.5. Иргэд, төрийн албан хаагчид, аж, ахуйн нэгж, байгууллагын ажилтнууд, сурагчид, иргэдийг соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулна.

1.6. Албан хаагч, ажилтан, иргэний сахилга, хариуцлагыг өндөржүүлэх арга хэмжээ авч ажиллана.

1.7. Байгууллага, аж ахуйн нэгжийн дотоод хяналтын үр нөлөөг сайжруулна.

1.8. Зорилтот бүлгийн нийгмийн асуудлыг шийдвэрлэнэ.

1.9. Амиа егүүтгэх гэмт хэрэг, гэр бүлийн хүчирхийллийн эсрэг гэмт хэрэг, зөрчлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сэтгэл зүйн болон хууль эрх зүйн нөлөөллийн арга хэмжээг хэрэгжүүлнэ.

2 дугаар зорилтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ

2.1. Салбар бүрт нарийвчилсан судалгаатай байна.

2.2. Гэмт хэрэг, зөрчил гарах орчин нөхцөлийг бүрдүүлэхгүй байна.

2.3. Хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах, сургалт сурталчилгаа хийнэ.

2.4. Жил бүр гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх эдийн засаг, нийгмийн төлөвлөлтийг хийх, хөрөнгө зарцуулна.

2.5. Тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хөтөлбөрүүдийг шатандаа хэрэгжүүлэх хөрөнгийг шийдвэрлэж ажиллана.

2.6. Зорилтот бүлэгт чиглэсэн сургалт, сурталчилгаа, нийгэмшүүлэх үйл ажиллагааг зохион байгуулна.

2.7. Гэмт хэрэг, зөрчлийн хэргээс урьдчилан сэргийлэх ажил нь хүн, хуулийн этгээдийн хоорондын харилцаанд хамаарагдах тул төрийн болон төрийн бус байгууллагын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, бодлогын нэгдмэл байдлыг хангах, байгууллага, орон нутагт албан хаагч, ажилчдын эрх зүйн боловслыг дээшлүүлэх, соён гэгээрүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулж ажиллана.

Байгууллагууд дотооддоо ажиллагсдын эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, соён гэгээрүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулж ажиллана.

3 дугаар зорилтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ

3.1.1. Зохион байгуулж удирдах чиг үүрэг бүхий хүний нөөц: Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага болох аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь нутаг дэвсгэрийн иргэдийн эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах ажлыг зохион байгуулж, хууль тогтоомж, хурлын шийдвэрийг тайлбарлан таниулах эрх үүргийнхээ хүрээнд гэмт хэрэг, зөрчлийн хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх ажлын уялдаа холбоо, хамтын ажиллагааг сайжруулах, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх, хөрөнгө мөнгө хуваарилах шийдвэрлэх, хурлын дэргэдэх Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн ажлыг удирдан зохион байгуулах чиг үүрэгтэй хамтран оролцоно.

3.1.2. Аймаг, сумын Засаг дарга нь нутаг дэвсгэртээ төрийн удирдлагыг хэрэгжүүлэх, чиг үүрэг бүхий төрийн төлөөлөгчийн хувьд хөтөлбөрийн биелэлтийг хангах ажлыг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулж, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хүний, санхүүгийн, материалын нөөцийг бүрдүүлэх, бааз суурийг бэхжүүлэхэд бүхий л талаар дэмжлэг үзүүлэн хамтран оролцоно.

3.2.1. Гүйцэтгэх чиг үүрэг бүхий хүний нөөц: Гэмт хэрэг, зөрчлийн хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг биечлэн зохион байгуулах, хариуцан ажиллах чиг үүрэг бүхий аймаг, сумын Засаг даргын Тамгын газрууд нь хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд бодлогын удирдамжаар хангах, хяналт, шинжилгээ үнэлгээ хийх, иргэдийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлсны үндсэн дээр хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг жил бүр батлуулан хэрэгжүүлж, тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчлийн хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх хөтөлбөрүүдтэй уялдуулан хөтөлбөрийн хэрэгжилт үр дүнг хариуцан ажиллана.

3.2.2. Багийн Засаг дарга нь нутаг дэвсгэртээ төрийн удирдлагыг хэрэгжүүлэх анхан шатны төрийн төлөөлөгчийн хувьд багийн иргэдийн нарийвчилсан судалгааг гаргах, мэдээ, мэдээллээр хангах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх ажилд харьяалах иргэдийг бүрэн хамруулах, хамтарч ажиллах, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд багийн айл өрхийг системтэй зохион байгуулах чиг үүрэгтэй оролцоно.

3.2.3. Аймгийн хууль сахиулах болон хяналтын байгууллагууд, ГХУСАЗ салбар Зөвлөл нь: Аймгийн хэмжээнд гарч байгаа гэмт хэрэг зөрчил, шүүхээр шийдвэрлэгдэж буй хэрэг маргааны шалтгаан нөхцөлийг судалж, бусад байгууллагад ашиглагдах статистик мэдээллийг гаргаж өгөх, гэмт хэрэг, зөрчлийн хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр мэргэжил арга зүйгээр хангах, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд эрхлэх асуудлын хүрээнд зөвлөмж, зөвлөгөө туслалцаа үзүүлэх, хяналт шалгалтын үр нөлөөг дээшлүүлэх, зорилтод бүлэгт чиглэсэн эрх зүйн албан бус сургалт, сурталчилгааг зохион байгуулах, гэмт хэрэг, зөрчлийн хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх ажлыг төрийн болон төрийн бус байгууллагууд, иргэдийн оролцоонд түшиглэн хамтран зохион байгуулж оролцоно.

3.2.4. Төрийн захиргаа, төрийн үйлчилгээний байгууллага: /нийтлэг/

Бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах чиг үүрэг бүхий аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэрэгжүүлэгч агентлагууд, аймгийн ИТХ-ын ажлын алба, сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга, төрийн бусад байгууллагууд, иргэд, ажилтнуудын аюулгүй амгалан амьдрах, ажиллах орчинг бүрдүүлэх чиг үүрийнхээ дагуу иргэдэд хүртээмжтэй, бодитой үйлчилгээг хүргэж гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд хамтран ажиллаж, төрийн албан хаагчдыг чадавхижуулах, алба хаагч, ажилтнуудтай холбоотой хэрэг, маргааны статистик судалгааг гаргаж, холбогдох арга хэмжээ авах, төрийн албан хаагчийн ёс зүй, хариуцлагыг дээшлүүлэх, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зөвлөгөө, зөвлөмж өгч, эрх зүйн чиглэлээр тусгайлсан мэдлэг мэдээлэлтэй болгох, салбарын сургагч багийг бэлтгэхэд дэмжлэг үзүүлэн сургагч төрийн албан хаагчдын баг бүрдүүлэх, албан хаагчдыг сургах, давтан сургах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд төрийн албан хаагчдын манлайллыг хангах, төрийн байгууллага болон байгууллагын орчинд гэмт хэрэг, зөрчилгүй ажиллах, гэмт хэрэг, зөрчил гарах шалтгаан нөхцөл, эрсдлийг арилгаж бусдад дууриал болох гэмт хэрэг, зөрчлийн хэргээс урьдчилан сэргийлэх тэмцэх ажилд бусад төрийн байгууллага, хууль хяналтын байгууллага, төрийн бус байгууллага, иргэдтэй хамтран ажиллана.

3.2.5. Боловсрол, соёл, урлагийн байгууллагууд: /тусгай/ Гэмт хэрэг, зөрчлийн хэрэг гарахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр ерөнхий боловсролын сургуульд тусгайлсан хөтөлбөрөөр сурагчдыг хүнлэг, энэрэнгүй, ёс суртахуун заншил, соёлын үнэт зүйлийг эрхэмлэн дээдэлдэг, амьдралдаа хэрэглэдэг иргэн болгон төлөвшүүлэх,

хүүхдүүдийн хичээлээр олж авсан мэдлэгийг амьдралд хэрэглэх арга зүйд суралцуулахад бусад байгууллагатай хамтран ажиллана.

Эрх зүйн соёл, ёс зүйтэй иргэнд байх чадваруудыг хүүхэд ахуй цагаас нь олгох ажлыг аймгийн Боловсрол, соёл, урлагийн газар, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар, ерөнхий боловсролын сургуулиуд, бусад байгууллагуудтай хамтран зохион байгуулна. Сургуулиудад орон тооны сэтгэл зүйч ажиллуулах, тандалт судалгаа хийх, сэтгэл зүйн боловсрол олгох, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулж зөвлөгөө өгч холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана.

Соёл, урлагийн байгууллагууд: Иргэд, өсвөр үед чиглэсэн, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хүний ёс, зүй, нинжин сэтгэл, дотоод мөн чанарт чиглэсэн иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн урлаг, үйлчилгээгээр үйлчилэхэд түлхүү анхаарч бусад байгууллагуудтай хамтран ажиллана.

3.2.6. Эрүүл мэндийн байгууллагууд /тусгай/ Халдварт бус өвчин түүний дотроос сэтгэцийн эмгэгээс урьдчилан сэргийлэх үзлэгийг жил бүр бүх сумдад зохион байгуулж, тандалт судалгаа хийж, эрт илрүүлэх, эмчлэх, архины хамааралтай хүмүүст сургалт, сурталчилгаа хийх, архинд донтох эмгэгтэй хүмүүст сайн дурын эмчилгээ, үйлчилгээ үзүүлэх, архины хор хөнөөлийн талаархи сургалт, сурталчилгааг холбогдох байгууллагуудтай хамтран тогтмол зохион байгуулж ажиллана.

3.2.7. Хувийн хэвшил, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагууд: Хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагууд нь байгууллага, байгууллагын орчинд гэмт хэрэг, зөрчилгүй ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлэх, ажилтнуудаа гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх ажилд татан оролцуулах, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх эрх зүйн сургалт, сурталчилгаа хийх, зөвлөгөө өгөх, ажлуудыг зохион байгуулж, ажилтнуудын эрх зүйн мэдлэгийг дээшлүүлж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллага, иргэдтэй хамтран ажиллана. Иргэд, байгууллага болон зорилтот бүлгүүдэд чиглэсэн сургалт зохион байгуулна.

3.2.8. Хэвлэл мэдээллийн байгууллагууд: Орон нутгийн радио, телевиз, сонин нь иргэдийн мэдээллийг хүлээн авах чухал хэрэгслийн хувьд Орон нутгийн төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зайны сургалт, сэдэвчилсэн нэвтрүүлэг, сурталчилгааны ажлыг зохион байгуулах боломж нөхцөл бүрдүүлж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр эрх зүйн сургалт сурталчилгааны нэвтрүүлэг бэлтгэн явуулах, ном, сэтгүүл, гарын авлага материал бэлтгэх, тараах, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах, эрх зүйн албан бус сургалт сурталчилгааны төсөл хөтөлбөрийг боловсруулан бие даан хэрэгжүүлж хамтран ажиллана.

3.2.9. Хамтарсан баг, ажлын хэсэг, зөвлөл: Хүүхэд хамгааллын хамтарсан баг, эрх зүйн хөтөч, сургалт сурталчилгааны хамтарсан баг, тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хэсэг, зөвлөл, эцэг, эхийн зөвлөл, Комиссууд зэрэг хамтарсан баг, зөвлөл, ажлын хэсгүүд энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиг үүрэг, ажлаа уялдуулан зохион байгуулж, төлөвлөн, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөвлөгөө, зөвлөмж өгөх, сургалт сурталчилгааг бусад төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулна.

3.3.1. Идэвхитэй оролцох чиг үүрэг бүхий хүний нөөц: Иргэд, сайн дурын үндсэн дээр эвлэлдэн нэгдсэн бүлэг, холбоо, нөхөрлөлийн гишүүд, системийн зохион байгуулалтанд хамрагдагсад нь хэрэгжүүлж байгаа хөтөлбөрт иргэний үүрэг хариуцлагынхаа хувьд идэвхитэй хамтран ажиллаж, эрх зүйн мэдлэг, соёлоо сайжруулж, сайн ажилласныхаа төлөө урамшуулал, дэмжлэг авах эрхтэй оролцоно.

Хөтөлбөрт оролцохдоо иргэд гэмт хэрэг, зөрчлийн хэрэг гарахаас урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр эвлэлдэн нэгдэж бүлэг, холбоо, нөхөрлөл зэргийг байгуулж зохион байгуулалтад орох, төрийн байгууллага, иргэний нийгмийн байгууллагатай хамтран ажиллах, гэмт хэрэг, зөрчлийн талаар мэдээ, мэдээлэл өгөх, хууль эрх зүйн мэдлэг боловсролоо дээшлүүлэх, хүүхэд залуучуудын хүмүүжил, төлөвшилд, онцгой анхаарч, хүүхдийг ёс суртахуунтай зөв хүн болох орчинг бүрдүүлэх, холбогдох төрийн болон төрийн бус байгууллагаас зохион байгуулж байгаа гэмт хэрэг, зөрчлийн хэрэг гарахаас урьдчилан сэргийлэх ажилд идэвхи санаачлагатай хамтран оролцож, иргэний үүрэг, хариуцлагаа ухамсарлаж, үйл ажиллагаандаа шаардлагатай бол төрөөс дэмжлэг авч оролцоно.

3.4. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүний нөөцийг чадавхижуулах, мэргэшүүлэх ажлыг тасралтгүй зохион байгуулна.

3.5. Гэмт хэрэг, зөрчлийн хэргээс урьдчилан сэргийлэх тэмцэх ажилд техник хэрэгсэл, бусад нөөцийг бүрдүүлнэ. Үүнд

3.5.1. Санхүүгийн нөөц

3.5.1.1. Аймаг, сумын төсөвт гэмт хэрэг, зөрчлийн хэрэг гарахаас урьдчилан сэргийлэх зардлыг тусгайлан тусгах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр гарсан төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх хөрөнгийг энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардалтай хамтатган шийдвэрлэнэ. Жил бүр хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний зардлыг баталж өгнө.

3.5.1.2. Иргэдийг гэмт хэрэг, зөрчлийн хэрэг гарахаас урьдчилан сэргийлэх, тэмцэх ажилд татан оролцуулж системээр идэвхитэй ажиллаж байгаа иргэдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх хөрөнгийг шийдвэрлэнэ.

3.5.1.3. Гэмт хэрэг, зөрчлийн хэрэг гарахаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, илрүүлэх ажилд идэвхитэй оролцогчдыг урамшуулах зардлыг жил бүр хүрэлцэхүйц хэмжээгээр төлөвлөн зарцуулна.

3.5.1.4. Гэмт хэрэг, зөрчлийн хэрэг гарахаас урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр хөрөнгө оруулалтыг төсөл, хөтөлбөр боловсруулах хэлбэрээр хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт, олон улсын байгууллагын дэмжлэг, тусламж авах замаар шийдвэрлүүлж болно.

3.5.2. Материалын нөөц

3.5.2.1. Хууль сахиулах байгууллагуудад гэмт хэрэг, зөрчлийн хэрэг гарахаас урьдчилан сэргийлэх, тэмцэх ажилд шаардлагатай, техник, тоног төхөөрөмж нэн хэрэгцээтэй хэрэглэгдэхүүнээр хангах, гэмт хэрэг, зөрчил гарч байгаа шалтгаан нөхцөлийг арилгахад шаардагдах хөрөнгийг жил бүр төлөвлөн санхүүжүүлэх зарчмыг баримталж ажиллана.

3.5.2.2. Байгууллага, аж ахуйн нэгж нь гэмт хэргээс урьдчилан тэмцэх ажилд зарцуулах хөрөнгийг шийдвэрлэж ажиллана.

3.5.2.3. Иргэд нь гэмт хэрэг, зөрчлийн хэрэг гаргахаас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд өөрсдийн аюулгүй байдлыг хангахад оршин суугаа хашаа, байшин байрандаа хөрөнгө оруулалт хийнэ.

3.5.2.4. Гэмт хэрэг, зөрчлийн хэрэг гарахаас урьдчилан сэргийлэх, тэмцэх ажилд иргэний нийгмийн байгууллага, төрийн бус байгууллага, иргэдийн үүсгэл санаачлага, иргэдийн оролцоог дэмжсэн техник тоног, төхөөрөмжийг олгоно.

3.5.2.5. Хүн, хүч, техник хэрэгслэлийн нөөц боломжийг зөв оновчтой хэлбэрээр зохион байгуулна.

4 дүгээр зорилтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ

4.1. Гэмт хэрэг, зөрчлийн хэрэг гарахаас урьдчилан сэргийлэх, тэмцэх хамтын ажиллагааны нэгдсэн тогтолцоог бий болгож бэхжүүлнэ.

4.2. Байгууллагын тусгай чиг үүрэгтэй холбоотой болон төр, байгууллага, хувь хүний нууцтай холбоотой асуудлаас бусад асуудлын мэдээллийг солилцох нөхцөл боломжийг бүрдүүлж, харилцан мэдээлэл солилцож, үйл ажиллагаандаа ашиглана.

4.3. Хууль, хүчний байгууллагууд хуулиар зөвшөөрөгдсөн хүрээнд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр бусад байгууллагатай багаар хамтарч ажиллана.

4.4. Гэмт хэрэг, зөрчлийн хэрэг гарахаас урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр төрийн болон, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байгууллагууд, иргэд хамтарч ажиллан үр дүнд хүрнэ.

4.5. Орон нутагт, гэмт хэрэг, зөрчлийн хэрэг гарахаас урьдчилан сэргийлэх тэмцэх хүний нөөцийг бүрдүүлнэ. /удирдлага, гүйцэтгэх ажилтнууд, системийн зохион байгууллалт болон бусад зохион байгуулалтад оролцогчид, иргэд/

4.6. Орон нутагт ажиллаж байгаа гэмт хэрэг, зөрчлийн хэрэг гарахаас урьдчилан сэргийлэх, тэмцэх хүн хүчний ажиллах орчин, техник хэрэгсэл, санхүүгийн нөөцийг бүрдүүлнэ.

4.7. Гэмт хэрэг, зөрчлийн хэрэг гарахаас урьдчилан сэргийлэх ажилд иргэд дангаараа болон эвлэлдэн нэгдэж оролцогчдод төрийн байгууллагаас үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлж хамтарч ажиллана.

4.8. Иргэдийг соён гэгээрүүлэх, сургалт сурталчилгааны үр нөлөөг сайжруулж

- Багийн хэлбэрээр төрийн үйлчилгээг үзүүлэх
- Төрийн албан хаагчдыг чадавхжуулах
- Иргэдийг соён гэгээрүүлэх
- Телевизийн нэвтрүүлэг бэлтгэх
- Уралдаан, тэмцээн, аян зохион байгуулах
- Цахим сүлжээгээр мэдээллэх зэрэг хэлбэрээр зохион байгуулна.

4.9. Иргэд өөрсдийн амьдарч байгаа орчин нөхцөлөө сайжруулж, гэмт хэрэг, зөрчил гарах эрсдлээс урьдчилан сэргийлэхэд хамтарч ажиллана.

4.10. Аж ахуйн нэгж, байгууллагууд хууль тогтоомжийг хэрэгжүүлэн дотооддоо болон орчиндоо эрсдлээс урьдчилан сэргийлж ажиллана.

4.11. Аж ахуйн нэгж, байгууллагууд, иргэд нь төрийн байгууллага, төрийн бус байгууллагаас зохион байгуулж байгаа гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тэмцэх ажилд идэвхи санаачлагатай оролцоно.

5 дугаар зорилтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ

5.1 Эрх зүйн хөтөч багийн үйл ажиллагааг тогтмолжуулна.

5.2 “Иргэний танхим”-ыг үйл ажиллагааг ажиллах журмын дагуу байнгын тогтвортой үйл ажиллагаатай болгоно.

5.3 Эрх зүйн сургалт, сурталчилгаа хариуцсан мэргэжилтний ажлын байрыг мэргэжлийн боловсон хүчнээр хангуулна.

5.4 Сумдад эрх зүйн хөтөч нарыг бэлтгэнэ.

5.6 Эрх зүйн сургалт, сурталчилгааны үйл ажиллагааг тогтмолжуулна.

Зургаа. Хөтөлбөрийн удирдлага зохион байгуулалт

6.1. Хөтөлбөрийг аймгийн ИТХ-ын дарга, аймгийн Засаг дарга, аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга, ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга удирдлага зохион байгуулалтаар хангаж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

Хөтөлбөрийн хэрэгжүүлэгчид:

Нутгийн өөрөө удирдах байгууллага

Төрийн захиргааны байгууллага

Төрийн тусгай байгууллага хууль хяналтын байгууллага /ГХУСАЗСЗ/

Төрийн үйлчилгээний байгууллага

Төрийн бус байгууллага

Аж ахуйн нэгж, байгууллага

Хэвлэл мэдээллийн байгууллага

Холбоо, нөхөрлөл

Иргэд

6.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх байнгын ажиллагаатай орон тооны бус зөвлөлийг аймаг, сум, баг, байгууллага дээр байгуулж ажиллана.

6.3. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцыг жил бүр аймгийн Засаг даргын зөвлөл, аймгийн ИТХ-ын хурлаар хэлэлцүүлнэ.

6.4. Хөтөлбөрийн хэрэгжилтэд аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсээс жил бүр, Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын хэлтсээс 2 жил тутам хяналт-шинжилгээ үнэлгээ хийнэ.

6.5. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа: Хөтөлбөр 2023-2025 он, 2026-2028 он гэсэн 2 үе шаттай хэрэгжинэ.

6.6. Хөтөлбөрийн санхүүжилт:

- Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт

- Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт

- Олон улсын байгууллагын тусламж

- Төсөл, хөтөлбөр

- Бусад эх үүсвэр

/Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын санхүүжилт нь энэ хуулийн 46.1-д зааснаас гадна хуулиар хориглоогүй бусад санхүүжилтийн эх үүсвэрээс бүрдэнэ.

46.3.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулсан хөрөнгийг аймаг, нийслэлийн батлагдсан төсөв дээр нь нэмж олгох замаар төвлөрүүлж, сум, дүүргийн Салбар зөвлөл, гэмт хэргийн нөхцөл байдал, цаашидын төлөвийг харгалзан хуваарилж, зарцуулна./

6.7. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, шалгуур үзүүлэлтийг жил бүр батлуулж хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган, санхүүжилтийг шийдвэрлэнэ.

Долоо. Хөтөлбөрийн хүрэх үр дүн:

7.1. Гэмт хэрэг, зөрчлийн хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх ажлын нэгдсэн тогтолцоо бүрдэж, тогтвортой ажилладаг болсон байна.

7.2. Гэмт хэрэг, зөрчлийн хэргээс урьдчилан сэргийлэх тэмцэх ажилд хүн хүч, техник хэрэгслийн нөөц, хүчин чадал сайжирна.

7.3. Гэмт хэрэг, зөрчлийн хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх ажилд иргэдийн оролцоо, идэвхи дээшилнэ.

7.4. Тодорхой төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх хөтөлбөрүүдийн хэрэгжилт хангагдана.

7.5. Гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг арилгаж, бууруулна.

7.6. Гэмт хэргийн гаралт буурна.

7.8. Гэмт хэргийн илрүүлэлт, хохирол нөхөн төлүүлэлт, хөрөнгийн хамгаалалт битүүмжлэл сайжирна.

7.9. Иргэдийн ёс зүй, эрх зүйн мэдлэг олгох, соён гэгээрүүлэх ажлын үзүүлэлтийг тогтвортой болгоно.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх шалгуур үзүүлэлт

Гэмт хэрэг, зөрчлийн хэргийн гаралт, эрх зүйн суралт сурталчилгааны аймгийн дундаж үзүүлэлт, хүрэх түвшин